



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/285

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (23500 га, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Бугат, Орхон, Сэлэнгэ, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Булган сумдад)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 3-р багц (Хутаг-Өндөр, Сайхан сумдад 5340 га талбай)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Сайхан ойн төлөө" ХХК-тай 157,471,000 (нэг зуун тавин долоон сая дөрвөн зуун далан нэгэн мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Сайхан ойн төлөө" ХХК-ийн захирал (Д.Эрдэнэбулган)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 29-ний өдрийн А/285 дугаар  
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт А.Гантөмөр